

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 дугаар тушаалын  
6 дугаар хавсралт

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ХӨДӨЛМӨРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН  
ХАЛАМЖИЙН ХЭЛТЭСИЙН АХМАД НАСТНЫ ХАЛАМЖИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ  
БАДАРЧ ОВОГТОЙ МАЙЧИМЭГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д /д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Бие
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
1	Зорилт 1. ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ. "Нийгмийн халамж зорилтот бүлэгт чиглүүлэх, халамжийн мөнгөн дүнг нэмэгдүүлэх, орчин үеийн стандартыг нэвтрүүлэх зорилгоор эрх зүйн шинэчлэл хийж, хэрэгжүүлнэ."	100%	Засгийн газрын 2019 оны "Хөнгөлөлт ийн хэмжээг тогтоох тухай" 97 дугаар тогтоол	100%	Ахмад настны тухай хуулийн 8.1.2-т заасан ахмадын зориулалттай амралт, сувиллын нэг ор хоногт нийгмийн халамжийн сангаас олгох хөнгөлөлтийн хэмжээ 20,000 төгрөг байсныг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх тооцоо судалгааг хийж Засгийн газрын 2024 оны "Хөнгөлөлтийн хэмжээ шинэчлэн батлах тухай" 159 дүгээр тогтоолыг батлуулав. Ингэснээр ахмад настан амралт, сувиллын газарт сувилуулах хугацааг 7 хүртэлх хоногоор, эрхийн бичгийн нэг ор хоногт нийгмийн халамжийн сангаас олгох хөнгөлөлтийн хэмжээг амралтын газарт 35,000 (гучин таван мянган) төгрөгөөр, сувиллын газарт 40,000 (дөчин мянган) төгрөг	2024.06-12 сар	

			<p>Болгон нэмэгдүүлж 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлээд байна.</p>	
<p>2.</p> <p>Арга хэмжээ 1.2. Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх журам, дүрмийг шинэчлэн боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх</p>	<p>100%</p>	<p>Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын хавсралт, 2017 оны 31 дүгээр тогтоол</p>	<p>Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхтэй холбоотойгоор нийгмийн халамжийн сангаас ахмад настанд олгох дэмжлэг, хамрагдах нөхцөл, давтамжийн хугацаа, санхүүжилтийн зохицуулалтад орсон өөрчлөлтөд нийцүүлэн "Ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох журам", "Насны хишиг олгох журам"-ын төслийг тус тус шинэчлэн боловсруулав. Мөн "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулан "Журам батлах, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамд руу 2024.10.31-ний 01/1074 тоот албан бичгээр хүргүүлэн саналыг авч нэгтгэн Засгийн Газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр хүргүүлсэн.</p>	<p>2024.06-12 сар</p>
<p>3.</p> <p>Арга хэмжээ 1.3. Ахмад настны тухай хуульд заасан "Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх журам"-ын төслийг боловсруулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлуулах</p>	<p>100%</p>	<p>0</p>	<p>Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тусгагдсан ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлж, эрсдэлийн заргийг үнэлж, үнэлгээнд суурилан ахмад настны Цогц үйлчилгээ, асаргааны хувилбарт үйлчилгээг үзүүлэх журмын төслүүдийг боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн яам, түүний харьяа байгууллагын төлөөллийг оролцуулан ГБХНХЯ-ны Төрийн нарийн</p>	<p>2024.06-12 сар</p>

<p>4. Арга хэмжээ 1.4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хуулиар тусгайлан эрх олгогдсон зохицуулалтад дүн шинжилгээ хийх, холбогдох хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллах</p>			<p>Бичгийн даргын 2024.09.27-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хурлыг 4 удаа зохион байгуулж, "Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж үйлчилгээ үзүүлэх журмын төслийг боловсруулан аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, Монголын ахмадын холбоо, Монголын Чөлөөт ахмадын холбоо болон бусад халамжийн үйлчилгээ үзүүлдэг Төрийн бус байгууллагуудын саналыг авч тусгав. Мөн журмын төсөлд иргэд олон нийтийн саналыг авахаар яамны вэбсайтад байршуулсан. "Журам батлах тухай" Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалын төслийг хянан үзэж батлуулах тухай албан бичгийг 2024.11.29-ны өдрийн 01/1427 тоот албан бичгээр хүргүүлэн дараах журмуудыг батлуулсан.</p> <p>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн "Журам батлах тухай" А/76,515, А/75,514 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам", "Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журам"-ыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн болно.</p> <p>ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024.01.10-ны А/01 тушаалаар байгуулагдсан Салбарын хуулиар тусгайлан эрх олгогдсон зохицуулалтад дүн шинжилгээ хийх, холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажиллан Нийгмийн халамжийн чиглэлийн 6 хууль болон бусад салбарын холбогдох</p>
<p>2024.06-12 сар</p>			

**Зорилт 2. "ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ"**

	100%	0	100%	Хуульд дүн шинжилгээ хийж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, танилцуулга, үзэл баримтлалын төслийг боловсруулж, хуулийн төслүүдийг ХЗДХЯ-нд хүргүүлсэн.	
1.	100%	0	100%	<p>“Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний цахим систем”-ийн хөгжүүлэлт хийхэд Зөвлөх багт дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг байгуулах, холбогдох байгууллагатай хамтран ажиллах, хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулах</p> <p>Арга хэмжээ 2.1. “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний цахим систем”-ийн хөгжүүлэлт хийхэд Зөвлөх багт дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг байгуулах, холбогдох байгууллагатай хамтран ажиллах, хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулах</p>	2024.01-06 сар
2.	100%	Асрамжийн газрын 2020 оны магадлан	100%	<p>Төрөлжсөн асрамжийн газрыг магадлан итгэмжлэх Орон тооны бус зөвлөлд орж ажиллан ажлын хэсгийн 3 удаагийн хуралд оролцож, Ватиканы ТГ-ын харьяа Тереза асрамжийн газар, шинээр магадлан итгэмжлэлд хамрагдах хүсэлт гаргасан Өлзийт Асар ТББ-д 2024.03.13-ны өдөр</p>	2024.01-06 сар

		ИТГЭМЖЛЭЛ ИЙН ТАЙЛАН		ажилласан. Магадлан итгэмжлэлд хамрагдсан 12 асрамжийн газрын үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жилээр сунгаж, асрамжийн үйлчилгээ үзүүлэхээр шинээр хүсэлт гаргасан 1 байгууллагад шаардлага хангаагүй тул ажил, үйлчилгээ явуулах эрх олгоогүй.	
--	--	-------------------------	--	--	--

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биел: тийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
1.	<b>Арга хэмжээ 2.1</b> Арга хэмжээ 1. Нийгмийн халамжийн чиглэлийн онолын болон практик мэдлэгээ нэмэгдүүлэх.	Сургалтын тоо-1	0	100%	Нийгмийн халамжийн чиглэлээрх олон улсын сайн туршлага, хөтөлбөрүүдийг судлан, олон Улсын байгууллагаас хийсэн судалгаа тайлангийн материалтай танилцан мэдлэгээ дээшлүүлж байна. 2024 оны 10 дугаар сард зохион байгуулагдсан "Social protection Forum"-д оролцож 5 улсын туршлагатай танилцсан.	2024.06-12 сар		

	Ахмад настны үйлчилгээ, идэвхтэй насжилт, урт хугацааны тусламж, үйлчилгээний чиглэлээр олон улсын туршлага судлах	Сургалтын тоо-1	0		Ахмад настны урт хугацааны тусламж, үйлчилгээ, эрүүл идэвхтэй насжилтыг дэмжих бодлого, хэрэгжилтийн талаар Азийн улс орнуудын туршлага солилцох чиглэлээр Индонез улсад болсон сургалтад 2024.09.08-09.12-ны өдрүүдэд хамрагдсан. Мөн ахмад настны эрүүл идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээ, ахмадын асаргааны хувилбарт үйлчилгээ, тэдгээрийн үнэ тариф, аргачлалыг тогтоох талаар олон улсын зөвлөхөөс туршлага судлав.	
2.	Арга хэмжээ 2.2.Монгол бичгийн мэдлэг, чадвараа дээшлүүлэх	Гүйцэтгэлийн хувь	0	70 %	Монгол бичгийн мэдлэг чадвараа сайжруулах зорилгоор бичих, богино хэмжээний эх унших дадлага хийж байна.	2024.06-12 сар

ТАЙЛАН ГАРГАСАН:

НХХ-ийн Шинжээч  
( Албан тушаал )

Б.Майчимэг /  /  
( Нэр, гарын үсэг )

2024.12.15  
( Огноо )